



ГАДААДАД ЭМЧЛҮҮЛЭГСДИЙН ЗАРДЛЫН СУДАЛГАА

СУДЛААЧ:

Э.ЭНХЦЭЦЭГ (ХТХАА-ны мэргэжилтэн)

ЗАХИАЛАГЧ БАЙГУУЛЛАГА:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ

НЭГ. УДИРТГАЛ

1.1. Үндэслэл

Эрүүл мэндийн яам нь Монгол Улсын бүх хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг ялгаварлан гадуурхалгүй, тэгш, хүртээмжтэй үзүүлэх хууль эрхзүйн үүрэгтэй бөгөөд Эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5 дахь хэсэг Засгийн газрын “Журам батлах тухай” 2011 оны 226 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2017 оны “Жагсаалт, журам шинэчилэн батлах тухай” А/370 дугаар тушаал, батлагдсан зайлшгүй шаардлагаар гадаад улсад эмчлүүлэх өвчний жагсаалт, Эрүүл мэндийн сайдын 2018 оны “Журам шинэчилэн батлах тухай” А/206 дугаар тушаалын хэрэгжилтийн хүрээнд энгийн иргэдэд Эрүүл мэндийн сайдын багцад жил бүр 500 сая төгрөг сууж жилдээ дунджаар 120 гаруй иргэнд гадаад улсад эмчлүүлсэн төлбөрийн баримтанд үндэслэн 5 хувьтай тэнцэх мөнгөн дүнгийн дэмжлэг үзүүлж байна. Гэтэл төрийн албан хаагчид 60-аас доошгүй хувиар олгох нь Монгол улсын иргэдийг төр, энгийн иргэнээр ялгаварлан үзэх асуудал үүсээд байна. Иймд тус зардлыг Эрүүл мэндийн яамны төсөвт тусгах нь иргэн, төрийн албан хаагчдын ялгавартай нөхөн олговор нэг газарт төвлөрөх нь үндэслэл муутай байна.

Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас Монгол улсад эмчлэгдэх боломжгүй өвчний жагсаалтыг гарган, зайлшгүй гадаад оронд оношлуулж, эмчлүүлэх шаардлагатай иргэдэд улсын төсвөөс тодорхой хэмжээний буцалтгүй тусламж үзүүлж байгаа нь нийгмийн өнөөгийн хэрэгцээ шаардлагыг хангахгүй байна.¹

Түүнчлэн Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 09-ны өдрийн “Журам батлах тухай” 6 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журам"-ын 7.3 дахь хэсэгт "... зайлшгүй шаардлагаар гадаад улсад эмчлүүлэх иргэнд санхүүжилт олгох тухай" Засгийн газрын баталсан журмыг баримтална гэж заасан. Одоо мөрдөж байгаа Засгийн газрын 2011 оны 226 дугаар тогтоолд төрийн албан хаагчдад зайлшгүй шаардлагаар гадаад улсад эмчлүүлсэн зардалд дэмжлэг үзүүлэх асуудлын талаар нарийвчлан тусгаагүй байна.

Иймд зайлшгүй шаардлагаар гадаад улсад эмчлүүлэх иргэн болон төрийн албан хаагчдад эмчилгээний зардлыг нөхөж олгох зохицуулалтыг тодорхой болгоход өнөөгийн нөхцөл байдлыг судлах шаардлага бий болж байна.

ХОЁР. ЗОРИЛГО, ЗОРИЛТ

2.1. ЗОРИЛГО

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 6 дугаар “Журам батлах тухай” тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тогтоолын төслийг боловсруулахад үндэслэл нотолгоог бүрдүүлж, өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, нөхцөл байдлыг тодорхойлоход оршино.

2.2. ЗОРИЛТ

- ЭМС-ын 2013 оны 313, 2015 оны 119, 2017 оны А/370 дугаар тус тус тушаалуудын өвчний нэр, эмчилгээний төрлийг нийцүүлж 2016-2018 оны байдлаар дүн шинжилгээ хийхэд бэлтгэх;
- Эрүүл мэндийн яамнаас 2016-2018 онуудад санхүүгийн буцалтгүй тусламж үзүүлж гадаад улсад эмчлүүлсэн эмчлүүлэгчдийн мэдээлэлд дүн шинжилгээ хийх;
- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 6 дугаар “Журам батлах тухай” тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тогтоолын төсөл

¹ ЭМХТ-ийн “Гадаадад эмчлүүлэгчдийн судалгаа” 2013 он

боловсруулах ажлын хэсэгт үндэслэл нотолгоо болох дүн шинжилгээ хийсэн үр дүнг танилцуулах;

ГУРАВ. СУДАЛГААНЫ АРГА, АРГАЧЛАЛ

3.1. Судалгааны хамрах хүрээ

Эрүүл мэндийн яамнаас 2016-2018 онуудад санхүүгийн буцалтгүй тусламж авсан иргэдийг хамруулсан.

3.2. Судалгааны загвар

Судалгааны ажиглалтын загварын дискритив аргыг ашигласан.

3.3. Судалгааны мэдээлэл цуглуулалт, боловсруулалт

Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн газраас 2016-2018 онуудад ЭМЯ-наас санхүүгийн буцалтгүй тусламж авсан иргэдийн мэдээлэл болон холбогдох ЗГ-ын тогтоол, хууль, ЭМС-ын тушаалуудыг баримтын аргаар цуглуулж энгийн статистик үзүүлэлтүүдийг EXCEL програмд тооцсон.


ДӨРӨВ. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Хүснэгт 1. Гадаад улсад эмчлүүлсэн нийт иргэдийн талаарх 2016-2018 оны дундаж мэдээлэл (Нийт 311 иргэн)

Он	Хүйсийн харьцаа (хувиар)		Эмчилгээнд зарцуулсан нийт зардал (тэрбум.төг)	Санхүүгийн дэмжлэг үзүүлсэн нийт мөнгөн дүн (сая.төг)
	Эрэгтэй	Эмэгтэй		
2016	53.3%	46.7%	5,476,405.30	296,798.50
2017	57.4%	42.6%	8,116,432	408,321.60
2018	50.5%	49.5%	8,445,629	432,967.50


2016-2018 онд гадаад улсад эмчлүүлсэн иргэдийн дийлэнх нь эрэгтэйчүүд байна. Нийт эмчилгээнд зарцуулсан зардлын 5%-тай тэнцэх нөхөн төлбөрийг Эрүүл мэндийн яамнаас олгосон байна.

Дүрслэл 1. Эмчилгээ хийлгэсэн тэргүүлэх улсууд (2016-2018 оны дунджаар)




Сүүлийн 3 оны байдлаар зайлшгүй шаардлагаар гадаад улсад эмчлүүлсэн нийт иргэдийг эмчлүүлсэн улсаар нь авч үзвэл БНСУ-д 28.6%, БНЭУ-д 22.8%, БНХАУ-27.7% бусад 11 улсад үлдсэн 20.9% нь эмчилгээ хийлгэхээр зорьсон байна.

Дүрслэл 2. Солонгос улсад эмчлүүлсэн иргэдийн тоо, оношоор (2016-2018 он)




Солонгос улсад нийт 88 иргэн эмчилгээ хийлгэж, үүнээс ихэнх хувийг хавдар (34.1%), эрхтэн шилжүүлэн суулгах мэс засал (23.9%), зүрх, судасны мэс засал (18.2%) эзэлж байна. Эрхтэн шилжүүлэн суулгах мэс засал эрэгтэй 17, эмэгтэй 4, зүрх, судасны мэс засал эрэгтэй 9, эмэгтэй 7 буюу дийлэнх нь эрэгтэй байгаа бол хавдар эрэгтэй 11, эмэгтэй 19 буюу эмэгтэйчүүд их эмчлүүлсэн байна. Хятад улсад нийт 81 иргэн эмчлүүлж, үүнээс иргэдийн ихэнх нь хавдар (32.1%), мэдрэлийн мэс засал (25.9%), зүрх, судасны мэс заслаар (23.5%) эмчилгээ хийлгэсэн байна. Үүнээс дийлэнх нь эрэгтэйчүүд байна. Энэтхэг улсад нийт 71 иргэн эмчилгээ хийлгэж, үүнээс 60.6 хувийг эрхтэн шилжүүлэн суулгах мэс засал эзэлж байна.

Дүрслэл 3. Хятад улсад эмчлүүлсэн иргэдийн тоо, оношоор (2016-2018 он)



Хятад улсад эмчлүүлсэн иргэдийн ихэнх нь хавдар, мэдрэлийн мэс засал, зүрх, судасны мэс заслаар эмчилгээ хийлгэсэн байна. Үүнээс дийлэнх нь эрэгтэйчүүд байна.

Дүрслэл 4. Энэтхэг улсад эмчлүүлсэн иргэдийн тоо, оношоор (2016-2018 он)



Энэтхэг улсад нийт 71 иргэн эмчилгээ хийлгэж, үүнээс 60.6 хувийг эрхтэн шилжүүлэн суулгах мэс засал эзэлж байна.

Хүснэгт 2. ЭМЯ-наас нийт санхүүгийн дэмжлэг авсан иргэдийн тоо

№	Эмчлүүлсэн улс	Иргэдийн тоо, оноор			НИЙТ
		2016	2017	2018	
1	АНУ		1	1	2
2	Герман	1	1	3	5
3	Казахстан			1	1
4	Орос		1	1	2
5	Польш			1	1
6	Сингапур	1	2		3
7	Солонгос	33	35	21	89
8	Тайвань	2	2	2	6
9	Тайланд	4	2	1	7
10	Турк		2	2	4
11	Франц			1	1
12	Хятад	23	28	35	86
13	Энэтхэг	20	15	36	71
14	Япон	8	5	6	19
	Эмчлүүлсэн улс тодорхойгүй		14		14
	НИЙТ	92	108	111	311

2016-2018 оноор авч үзвэл, Эрүүл мэндийн яамнаас 2017 онд хамгийн их иргэн санхүүгийн дэмжлэг авсан байна. Эрүүл мэндийн сайдын багцад жил 500 сая төгрөг сууж, жилд дунджаар 104 орчим иргэнд санхүүгийн дэмжлэг үзүүлсэн байна.

Хүснэгт 3. 2016 онд гадаад улсад эмчилгээ хийлгэсэн иргэдийн дундаж мэдээлэл, улсаар

Эмчлүүлсэн улс	Хүний тоо	Эмчлүүлсэн дундаж зардал (сая.төг)	Шийдвэрлэсэн дундаж мөнгөн дүн (сая.төг)
Герман	1	95,216.0	4,900.0
Сингапур	1	41,393.9	2,069.7
Солонгос	33	63,291.1	3,428.3
Тайвань	2	30,091.0	2,500.0
Тайланд	4	84,210.8	4,237.5
Хятад	23	32,859.7	1,908.5
Энэтхэг	20	66,377.3	3,647.4
Япон	8	96,355.9	4,737.7
НИЙТ	92	59,526.1	3,226.1


Хүснэгт 4. 2017 онд гадаад улсад эмчилгээ хийлгэсэн иргэдийн дундаж мэдээлэл, улсаар

Эмчлүүлсэн улс	Хүний тоо	Эмчлүүлсэн дундаж зардал (сая.төг)	Шийдвэрлэсэн дундаж мөнгөн дүн (сая.төг)
АНУ	1	10,214.4	510.7
Герман	1	63,720.0	3,186.0
ОХУ	1	27,238.8	1,361.9
Сингапур	2	78,551.9	3,927.6
Солонгос	35	72,846.7	3,642.3
Тайвань	2	44,662.2	2,233.1
Тайланд	2	19,070.0	953.5
Турк	2	9,769.6	488.5
Хятад	28	83,873.7	4,193.7
Энэтхэг	15	107,647.1	5,382.4
Япон	5	38,207.3	1,910.4
Эмчлүүлсэн улс тодорхойгүй	14	75,522.2	3,776.1
НИЙТ	108	75,615.1	3,780.8

Хүснэгт 5. 2018 онд гадаад улсад эмчилгээ хийлгэсэн иргэдийн дундаж мэдээлэл, улсаар


Эмчлүүлсэн улс	Хүний тоо	Эмчлүүлсэн дундаж зардал (сая.төг)	Шийдвэрлэсэн дундаж мөнгөн дүн (сая.төг)
АНУ	1	73,902.6	3,695.0
Герман	3	30,816.2	1,714.3
Казахстан	1	4,787.7	500.0
Орос	1	9,068.8	500.0
Польш	1	7,158.7	357.9
Солонгос	21	136,676.3	6,825.6
Тайвань	2	177,119.7	8,856.1
Тайланд	1	30,057.6	1,503.0
Турк	2	64,438.8	3,221.9
Франц	1	136,010.0	6,801.0
Хятад	35	31,027.0	1,735.0
Энэтхэг	36	86,872.8	4,340.7
Япон	6	89,251.4	4,997.1
НИЙТ	111	76,176.8	3,900.6

Дүрслэл 5. Гадаад улсад эмчлүүлсэн иргэдэд ЭМЯ-наас олгосон санхүүгийн дэмжлэг (2016-2018 он)




2016-2018 оны дунджаар хавдар, эрхтэн шилжүүлэн суулгах мэс засал, зүрх судасны мэс заслаар эмчилгээнд хамрагдсан иргэд нь нийт иргэдийн 75.6% болон нийт Эрүүл мэндийн яамнаас үзүүлсэн санхүүгийн дэмжлэгийн 78.5%-ийг тус тус эзэлж байна.

Дүрслэл 6. Гадаад улсад эмчлүүлсэн иргэдийн онош, хувиар (2016-2018 он)




2016-2018 онд гадаад улсад эмчлүүлсэн иргэдийн тэргүүлэх онош болох мэдрэлийн мэс засал, зүрх, судасны мэс засал, хавдар, эрхтэн шилжүүлэн суулгах мэс заслыг доор нарийвчлан үзвэл:

Дүрслэл 7. Эрхтэн шилжүүлэн суулгах мэс заслын , 2016-2018 оны дунджаар




- Донороос реципентэд ясны чөмөг шилжүүлэн суулгах
- Элэгний вирусын идэвхижил өндөр болон реципентэд элэг, бөөр шилжүүлэн суулгах
- Тунгалагийн судасны гаж хөгжлийн нөхөн сэргээх мэс засал /Зааны хөл гэмээр өөрчлөлт/
- Шээсний сүвийн арын хэсгийн гэмтлийг эсвэл давсагны өмнөд ханагүй гажгийн үеийн давсагны хүзүүвч орчмыг нөхөн сэргээх мэс засал

Дүрслэл 8. Хавдар, 2016-2018 оны дунджаар



- Толгой хүзүүний өргөтгөсөн мэс заслын дараахь согог, эрхтнийг хиймэл эрхтэн буюу протезоор орлуулах (хиймэл төвөнх), нармайн хавдрын мэс засал эмчилгээ
- Цагаан мөгөөрсөн хоолойн хавдрын эмчилгээ
- Яс, зөөлөн эдийн хавдрын нөхөн сэргээх мэс засал Мөч хадгалах боломжтой үеийн хорт хавдар Бага аарцаг, цээжний хөндийн байрлалтай хорт хавдар
- Тархи нугасны хавдрууд, толгой хүзүүний дахисан хавдрын үеийн стереотактик туяа эмчилгээ
- Улаан хоолой-цагаан мөгөөрсөн хоолойн фистул
- Ходоод гэдэсний тулгуурын хавдрын үеийн химийн эмчилгээ
- Д-28

Дүрслэл 9. Мэдрэлийн мэс засал, 2016-2018 оны дунджаар




- Тархи, нугасны гүний, төвөгтэй байрлалтай, мэс заслаар авах боломжгүй болон бусад ажилбар, эмчилгээ шаардагдах хавдар, хавдар тест эмгэгийн мэс засал эмчилгээ
- Паркинсоны өвчин, торсион дистонид стереотакс мэс заслын аргаар тархины гүний өдөөлт (deep brain stimulation) хийн, электрод суулгах эмчилгээ


Дүрслэл 10. Зүрх, судасны мэс засал, 2016-2018 оны дунджаар



Дүрслэл 11. Гадаад оронд эмчлүүлсэн иргэдийн онош (2016-2018 он)



Дүрслэл 12. Эмчилгээнд зарцуулсан дундаж зардал, оношоор (2016-2018 он)



2016-2018 ны дунджаар эмчилгээнд зарцуулсан нийт зардлын дийлэнх буюу 19.2 хувийг E-16 (Уушгины төрмөл гажгийн мэс засал) эзэлж байна. Дараа нь Ж-22 (Элэгний вирусын идэвхижил өндөр болон рецигентэд элэг, бөөр шилжүүлэн суулгах мэс засал) 6 хувийг, Ж-23 (Тунгалагийн судасны гаж хөгжлийн нөхөн сэргээх мэс засал, зааны хөл гэмээр өөрчлөлт) 5.6 хувийг тус тус эзэлж байна.

Дүгнэлт

2016-2018 оны дунджаар эмчилгээнд зарцуулсан нийт зардал 5,476,405.3-8,445,629 тэрбум.төг, үүнээс ЭМЯ-наас санхүүгийн дэмжлэг үзүүлсэн нийт мөнгөн дүн 296,798.5-432,967.5 сая.төг буюу эмчилгээнд зарцуулсан зардлын 5%-тай тэнцэх нөхөн төлбөрийг олгосон байна. Эрүүл мэндийн сайдын багцад жилд 500 сая төгрөг сууж, жилд дунджаар 104 орчим иргэнд санхүүгийн дэмжлэг үзүүлсэн байна.

Сүүлийн 3 оны байдлаар гадаад улсад эмчлүүлсэн нийт иргэдийн 28.6% Солонгос улсад, 27.7% Хятад улсад, 22.8% Энэтхэг улсад, бусад 11 улсад үлдсэн 20.9% нь эмчилгээ хийлгэхээр зорьсон байна. Солонгос улсад нийт 88 иргэн эмчилгээ хийлгэж, үүнээс ихэнх хувийг хавдар (34.1%), эрхтэн шилжүүлэн суулгах мэс засал (23.9%), зүрх, судасны мэс засал (18.2%) эзэлж байна. Эрхтэн шилжүүлэн суулгах мэс засал эрэгтэй 17, эмэгтэй 4, зүрх, судасны мэс засал эрэгтэй 9, эмэгтэй 7 буюу дийлэнх нь эрэгтэй байгаа бол хавдар эрэгтэй 11, эмэгтэй 19 буюу эмэгтэйчүүд их эмчлүүлсэн байна. Хятад улсад нийт 81 иргэн эмчлүүлж, үүнээс иргэдийн ихэнх нь хавдар (32.1%), мэдрэлийн мэс засал (25.9%), зүрх, судасны мэс заслаар (23.5%) эмчилгээ хийлгэсэн байна. Үүнээс дийлэнх нь эрэгтэйчүүд байна. Энэтхэг улсад нийт 71 иргэн эмчилгээ хийлгэж, үүнээс 60.6 хувийг эрхтэн шилжүүлэн суулгах мэс засал эзэлж байна. 2016-2018 оны дунджаар эрхтэн шилжүүлэн суулгах мэс засал нийт иргэдийн 27%, Эрүүл мэндийн яамнаас олгосон нийт санхүүгийн дэмжлэгийн дийлэнх буюу 45%-ийг эзэлж байна.

2016-2018 оны дунджаар хавдар, эрхтэн шилжүүлэн суулгах мэс засал, зүрх судасны мэс заслаар эмчилгээнд хамрагдсан иргэд нь нийт иргэдийн 75.6% болон нийт Эрүүл мэндийн яамнаас үзүүлсэн санхүүгийн дэмжлэгийн 78.5%-ийг тус тус эзэлж байна. 2016-2018 ны дунджаар эмчилгээнд зарцуулсан нийт зардлын дийлэнх буюу 19.2 хувийг E-16 (Уушгины төрмөл гажгийн мэс засал) эзэлж байна. Дараа нь Ж-22 (Элэгний вирусын идэвхижил өндөр болон реципентэд элэг, бөөр шилжүүлэн суулгах мэс засал) 6 хувийг, Ж-23 (Тунгалагийн судасны гаж хөгжлийн нөхөн сэргээх мэс засал, зааны хөл гэмээр өөрчлөлт) 5.6 хувийг тус тус эзэлж байна.

Ашигласан материал

1. Эрүүл мэндийн тухай хууль
2. Төрийн албаны тухай хууль
3. Засгийн газрын “Гадаад улсад эмчлүүлэх иргэнд санхүүжилт олгох журам батлах тухай” 2011 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 226 дугаар тогтоол
4. Засгийн газрын “Журам батлах тухай” 2019 оны 01 дүгээр сарын 09-ны өдрийн 6 дугаар тогтоол
5. Эрүүл мэндийн сайдын тушаал, “Гадаад улсад зайлшгүй шаардлагаар эмчлүүлэх өвчний жагсаалт, журам батлах тухай” 2013.08.29-ний өдрийн №313
6. Эрүүл мэндийн сайдын тушаал, “Журам шинэчилэн батлах тухай” 2015.03.31 – ний өдрийн №119
7. Эрүүл мэндийн сайдын тушаал, “Жагсаалт, журам шинэчилэн батлах тухай” 2017.09.21-ний өдрийн №А/370
8. Эрүүл мэндийн сайдын тушаал, 2016 оны №А/104, А/174, А/193, А/277
9. Эрүүл мэндийн сайдын тушаал, 2017 оны №А/116, А/217, А/314, А/410, А/411, А/511, А/527
10. Эрүүл мэндийн сайдын тушаал, “Гадаадад эмчилгээ хийгдсэн иргэдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх тухай”, 2018 оны №А/86, А/214, А/294, А/451, А/511, А/524
11. ЭМХТ-ийн “Гадаадад эмчлүүлэгчдийн судалгаа” 2013 он

Хавсралт 1. ЭМС-ын тушаалаар баталсан өвчний жагсаалт

Онош	№	Өвчний нэр
Мэдрэлийн мэс засал	A-1	Тархи, нугасны гүний, төвөгтэй байрлалтай, мэс заслаар авах боломжгүй болон бусад ажилбар, эмчилгээ шаардагдах хавдар, хавдар төст эмгэгийн мэс засал эмчилгээ
	A-2	Паркинсоны өвчин, торсион дистонид стереотакс мэс заслын аргаар тархины гүний өдөөлт (deep brain stimulation) хийн, электрод суулгах эмчилгээ
Чих хамар хоолой	Б-4	Вегенерийн өвчний хүнд хэлбэр үеийн эмчилгээ
Нүд судлал	В-6	Дутуу нярайн торлогийн эмгэгийн улмаас торлог ховхрох үеийн торлог шилэнцрийн мэс засал
Зүрх судасны мэс засал	Г-10	Гол судасны хүнд хэлбэрийн цүлхэн, хуулралын эмчилгээ
	Г-7	Зүрхний титэм судасны хүнд хэлбэрийн нарийсал, судасны дисплази эмчилгээ
	Г-8	Хүүхдийн хавсарсан хөх, хүнд гажигийн үеийн мэс засал эмчилгээ
	Г-9	Зүрхний том судаснуудын гаж байрлалын мэс заслын эмчилгээ
Хавдар	Д-13	Цагаан мөгөөрсөн хоолойн хавдрын эмчилгээ
	Д-14	Яс, зөөлөн эдийн хавдрын нөхөн сэргээх мэс засал Мөч хадгалах боломжтой үеийн хорт хавдар Бага аарцаг, цээжний хөндийн байрлалтай хорт хавдар
	Д-15	Тархи нугасны хавдрууд, толгой хүзүүний дахисан хавдрын үеийн стереотактик туяа эмчилгээ
	Д-21	Улаан хоолой-цагаан мөгөөрсөн хоолойн фистул
	Д-24	Ходоод гэдэсний тулгуурын хавдрын үеийн химийн эмчилгээ
Уушги	Е-16	Уушгины төрмөл гажгийн мэс засал эмчилгээ
Гэмтэл согог	Ё-17	Дээд болон доод мөчдийн төрөлхийн хүнд хэлбэрийн дутуу хөгжил, гэмтэл
	Ё-18	Хүзүү нурууны нугас тасарсан гэмтлийн хүнд үеийн мэс засал
Эрхтэн шилжүүлэн суулгах	Ж-20	Донороос реципентэд ясны чөмөг шилжүүлэн суулгах
	Ж-22	Элэгний вирусын идэвхижил өндөр болон реципентэд элэг, бөөр шилжүүлэн суулгах
	Ж-23	Тунгалагийн судасны гаж хөгжлийн нөхөн сэргээх мэс засал /Зааны хөл гэмээр өөрчлөлт/
Эх барих эмэгтэйчүүд, үргүйдэл	З-25	Ихэр жирэмсний үед ургаас урагт цус юүлэгдэх хам шинжийн үеийн лазер эмчилгээ
	З-37	Өндгөвчний төрөлхийн дутуу хөгжлөөс үүдсэн үргүйдэл